

**ГХБХБГ-ЫН 04 ДҮГЭЭР САРЫН 2 ДАХЬ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ,
СУДАЛГАА**

2016.04.14.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>Аймгийн татварын хэлтэст 2017 оны газрын төлбөрийн ногдуулалтыг гаргаж хүргүүлсэн.</p> <p>Газрын төлбөрийн тухай хуулийн төсөлд санал бичиж Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлэв.</p> <p>Аймгийн Тирлик захын урьд талын замын дагуу авто зогсоол баригдахаар болсон тул төлөвлөгдсөн газарт худалдаа наймаа хийж байгаа ард иргэдэд газар чөлөөлөх тухай хугацаатай мэдэгдэх хуудас өглөө.</p> <p>Улаанхус сумын Харуул гэдэг газарт газрын маргаанаар Шүүхийн газрын шүүгч нартай хамт газрын үзлэг хийж ирсэн.</p> <p>Барилгын салбарт төрөөс баримтлах бодлого /2017-2027/ боловсруулж байгаатай холбогдуулан ирүүлсэн маягтын дагуу аймгийн барилга, хот байгуулалтын салбарын суурь судалгаа, мэдээллийг хавсралтын дагуу гаргаж Аймгийн засаг даргын тамгын газарт хүргүүлсэн болно.</p> <p>НЖК ХХК-д үйлдвэрлэж байгаа элс /0-5/, дайргыг /5-10, 10-20..... / хэмжээгээр нь итгэмжлэгдсэн лабораторид бүрэн шинжилгээнд хамааруулах талаар мэдэгдэл хүргүүлсэн. Тус мэдэгдлийн дагуу НЖК компани элс, дайргыг Ховд аймгийн ГХБХБГазрын барилгын материалын лабораторид бүрэн шинжилгээнд хамааруулж байна.</p> <p>2017 оны 04-р сарын 12-нд БХБХэлтсийн дарга Х.Асхар, шинжээч М.Гүлжемис нар шинээр баригдаж байгаа иргэн н.Танайн орон сууц, иргэн н.Муратбекийн үйлчилгээний барилгад хөдөлмөрийн аюулгүй байдал болон ашиглаж байгаа барилгын материалуудын бүтээгдэхүүний баталгаажуулалт тохирлын гэрчилгээтэй эсэхийг шалгаж, бетоны цутгалт бүрээс авсан бетоны дээжид шинжилгээ хийлгэх талаар үүрэг даалгавар өгч хяналт шалгалт хийсэн болно.</p> <p>Талбай өөрчлөх -6, шинээр газар өмчлөх-11 иргэдийн материалыг хүлээн авч аймгийн Засаг даргын захирамж гаргуулав.</p> <p>Улаанхус сумын Хөх хөтөл багийн сургууль, Кувейт улсын хаус хороолол, Суат ХХК-ны хот доторх бохир усны шугам нэмж татах</p>	<p>Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

<p>"Хөх-Тас" хоршооны эзэмшил газар, иргэн Х.Аргоны 20 айлын орон сууцны байршил, МСҮТөвийн захирлын ажилчдын орон сууцны барилгыг байршил зэрэгт хотын ерөнхий төлөвлөгөөний ерөнхий шаардлага, инженерийн дэд бүтцийн даац болон холбогдох норм дүрэм, газрын тухай хуулийн заалт, Хот байгуулалтын хуулийг үндэслэн зөвлөмж хариу өгч ажиллав.</p> <p>Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 250 ортой Нэгдсэн эмнэлэг, стационар, гэмтэл согогийн эмнэлгийн байршлын зураг, эсхийз эх загварыг архитектур төлөвлөлтийн даалгаврын хамт боловсруулж батлав.</p> <p>Онцгой байдлын ажилчдын орон сууцны байршлын схем, архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлав.</p> <p>Тэс петролиум "Талын хоргүй" ХХК-иудын агуулахын байршлыг архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлав.</p> <p>2017-2027 онд төрөөс баримтлах бодлоготой холбоотой ерөнхий төлөвлөгөөний судалгааг сумуудаас авч нэгтгэв.</p> <p>Сумдын газрын даамлуудад Windows Accounts хэрэглэгчийн хаяг нээж өгч тохиргоо хийсэн. Алтанцөгц, Баяннуур, Булган, Бугат, Дэлүүн сумдыг VPN тохиргоо агентлагийн ОЗМТХэлтэст хийлгэж дууссаны дараа хэрэглэгчийн хаяг нээж өгөхөөр болсон.</p>		
--	--	--

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР